

## ЦССҮТ-ийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт шинжилгээний танилцуулга

2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр.

### Үнэлгээний зорилго

Төвийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хүрсэн түвшинг тогтоох, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг бодит мэдээллээр хангахад оршино.

### Үнэлгээний арга зүй.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачилал заавар батлах тухай” 100 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 сарын 01-ий өдрийн А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ” хийх нийтлэг журмыг тус тус үндэслэн төвийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.

### Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Төв нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачилал заавар батлах тухай” 100 дугаар тушаалын 4-р хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний маягтын дагуу 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилгын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргасан байна.

2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хүснэгт 1-ээр харуулав.

#### Хүснэгт 1.

Д/д	Байгууллага	Зорилгын тоо	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ						Дундаж хувь
				100	90	70	50	30	0.0	
1.	ЦССҮТ	6	57	53	4					99,2 хувь

**Хүснэгт.2. Гүйцэтгэл нь тухайн арга хэмжээний хүрэх түвшинд  
бүрэн хүрээгүй арга хэмжээ**

№	Төлөвлөгөөнд тусгагдсан заалтын дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үнэлгээ	Хугацаа	Тайлбар, анхаарах асуудлууд
1	9	ДЭМБ-д Цус сэлбэлт судлалын салбарын 2020 оны тайланг хүргүүлнэ.	90%	I-IV улирал	ДЭМБ-аас 2 жил тутам авдаг Цус сэлбэлт судлалын салбарын тайланг авах талаар мэдээлэл ирээгүй, линк тавигдаагүй хүлээгдэж байна. Тайлан илгээх линк хүссэн мэйл явуулсан шийдвэрлэгдээгүй.
2	29	Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлж хөлдөөсөн шинэ сийвэнгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	90%	I-IV улирал	2022 оны 12 сарын 15-ны байдлаар 2361 нэгж буюу зорилтот түвшингээс 1239 нэгж дутуу үйлдвэрлэсэн. 2022 оны тендерийн бараа материал хил, гаалийн нөхцөл байдалтай холбоотойгоор хугацаа хоцорч нийлүүлэгдсэнээс шалтгаалсан.
3	30	Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	90%	I-IV улирал	2022 оны 12 сарын 15-ны байдлаар 255 нэгж буюу зорилтот түвшингээс 235 нэгж дутуу үйлдвэрлэсэн. 2022 оны тендерийн бараа материал хил, гаалийн нөхцөл байдалтай холбоотойгоор хугацаа хоцорч нийлүүлэгдсэнээс шалтгаалсан.
4	31	Цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	90%	I-IV улирал	2022 оны 12 сарын 15-ны байдлаар 4620 нэгж буюу зорилтот түвшингөөс 731 нэгж дутуу үйлдвэрлэсэн. 2022 оны тендерийн бараа материал хил, гаалийн нөхцөл байдалтай холбоотойгоор хугацаа хоцорч нийлүүлэгдсэнээс шалтгаалсан.

**Дүгнэлт**

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан загварын дагуу боловсруулж ЭМЯ, төрийн захиргааны удирдлагын газраас аргазүйн зөвөлгөө авч, бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж хугацаанд нь батлуулж, хэрэгжүүлж ажилласан;

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон үйл ажиллагааны бусад тайлан бичих загварыг Google drive-д байршуулж нээлттэй, мэдээллээр хангах, харилцан суралцах нөхцлийг бүрдүүлсэн;
3. Хяналт шинжилгээ, үнэлгээгээр 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 99,2 хувьтай байна.

**Цаашид авах арга хэмжээ.**

1. 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, танилцуулгыг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;
2. Цаашид Хүснэгт.2-д туссан арга хэмжээний бүрэн биелээгүй шалтгааныг арилгахад чиглэсэн арга хэмжээ авах;
3. Тоон тайлан мэдээг гаргахдаа тайлангийн хамрах хугацааг тогтсон өдрөөр тасалбар болгож тайлан гаргах

ЗАХИРГАА, МАРКЕТИНГИЙН АЛБА

ДОТООД АУДИТОР

2022.12.12